



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.24 № 03/8905

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

“МОНГОЛЫН ИРГЭНИЙ
АГААРЫН ТЭЭВЭР” ТӨХК-Д

УТЗ Н. Чанс
УТЗ Б. Ганзориг нар
Халдагч хуулийн 48р
зүйлийн дагуу дахин
чухалх
2024.10.30

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240103122 дугаартай “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Монгол даатгал” ХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Монгол даатгал” ХК-ийн гомдолд тус компанийн тендерээс тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан ангарын болон газрын үйлчилгээний хариуцлагын үүний дотор даатгуулагч гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг хариуцах даатгалд хамруулсан байх шаардлага хангаагүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсан үндэслэлээр “Монгол даатгал” ХК-ийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэрийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.4-т “Давхар даатгалын хувьд: Ангарын болон газрын үйлчилгээний хариуцлагын үүний дотор даатгуулагч гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг хариуцах даатгалд хамруулсан байх” гэж заасан байна.

“Монгол даатгал” ХК-ийн тендерт ирүүлсэн Давхар даатгалын В0180QAV2403514 дугаартай гэрээний бүлэг 3: Агаарын тээврийн хариуцлагад “Даатгуулагчийн агаарын тээврийн болон авиацтай холбоотой бүх үйл ажиллагаа болон ашиг сонирхлоос үүдэн гарч болох хууль ёсны хариуцлагыг энэхүү бүлгээр хамгаалж нөхөн төлөх бөгөөд энэ нь AVN-59 Нисэхийн бус хариуцлагын заалтын хязгаарлалтуудтай нийцэн тодорхойлогдоно.” гэж заасан байна.

Гомдолд “дээрх заалт нь агаарын тээврийн бүхий л үйл ажиллагаанаас бусдад учруулах хохирлыг хариуцна гэсэн утгатай, тодруулбал “МИАТ” компанийн ангарын болон газрын үйлчилгээний хүрээнд гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг хариуцна

9766016643

УЛААНБААТАР ХОТ
МИАТ ТӨХК

ТТМ № 2287

Бүртгэсэн № ... карт № 1389

Он, сар, өдөр 2024.10.50

..... цаг минут

.....-д шилжүүлэв.

Хуудасны тоо

авчирга өгөв

гэсэн утгатай бөгөөд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Бодьдаатгал” ХК-ийн тендерт ирүүлсэн давхар даатгалын нөхцөлд “энэхүү баримт бичигт багтсан Нисэхийн бус хариуцлагын заалт (AVN-59)-ийн дагуу даатгуулагчийн үйл ажиллагаатай холбоотой буюу тэдгээрээс үүссэн хариуцлага (зарласан үнэ батгана)” гэж тусгасан байгаа нь “Монгол даатгал” ХК-ийн ирүүлсэн давхар даатгалын нөхцөлтэй адилхан” талаар дурдсан байх тул тус асуудлыг нягталж үзэх нь зүйтэй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/2505 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Монгол даатгал” ХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ